



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 2/57


Улаанбаатар хот

“Эрүүл иргэн аян” зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2017 оны “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлах тухай” 24 дүгээр, “Халдварт өвчнөөс сэргийлэх хянах тухай үндэсний хөтөлбөр батлах тухай” 11 дүгээр, “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 78 дугаар, “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 289 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 23/15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийг эрчимжүүлэх, өвчлөл, хүндрэлээс сэргийлэх зорилгоор “Эрүүл иргэн” аяныг 2019 оны 04 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.
2. “Эрүүл иргэн” аяны үйл ажиллагааны шаардагдах төсвийг хавсралт ёсоор баталсугай.
3. Эрүүл иргэн аяны санхүүжилтээр олгогдож буй төсвөөр иргэдэд халдварт болон халдварт бус өвчний талаар мэдээлэл, сургалт сурталчилгааны үйл ажиллагааг олон төрлийн мэдээллийн арга хэрэгслийг ашиглан үр дүнтэй зохион байгуулахыг НЭМ-ийн мэргэжилтэн /Ч.Гүнчинхорлоо/-д үүрэг болгосугай.
4. Аяныг хэрэгжүүлэх, явц, үйл ажиллагаанд хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг НЭМ-ийн орлогч дарга /Б.Лувсанням/-д үүрэг болгосугай.
5. Энэхүү арга хэмжээнд зарцуулагдах төсвийг нэмэлт санхүүжилтийн данснаас олгохыг ерөнхий нягтлан бодогч /Э.Чимидцэрэн/-д зөвшөөрсүгэй.
6. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг чанарын албаны дарга /Н.Оюунмэд/-д даалгасугай.


ДАРГА



Э.БОДЬЦЭЦЭГ

30170 70 0473

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн
.../57... тоот тушаалын хавсралт



“ЭРҮҮЛ ИРГЭН” АЯНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСӨВ

д/д	Барааны нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Бүгд үнэ
1	Гарын авлага	ш	350	9500	3 325 000
2	Тараах материал	ш	250	1500	375 000
3	Стэнд	ш	35 000	16	560 000
4	Хөргөгчний наалт	ш	1000	400	90 000
5	Шторк				1 000 000
6	Сургалтын зардал	ш	16	50 000	800 000
Нийт дүн					6 550 000